



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-24-80, Факс: 32-31-58, 26-06-13  
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2017.05.22 № 12/4119  
танай \_\_\_\_\_-ны № 06 \_\_\_\_\_-Т

2017 оны 06 тоотын хариу

Таны 2017 оны 06 тоот албан бичгээр ирүүлсэн асуулттай танилцлаа. Ард иргэдийн санал, хүсэлтийг уламжилж, тэднийхээ төлөөлөл болон ажиллаж байгаад тань талархал илэрхийлье.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 111 тоот тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын зээлийн сан нь “Оюутны хөгжлийн зээл”-ийг Монголбанкны үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг сайн хангасан Голомт, Хаан, Төрийн, Хас, Капитрон, Улаанбаатар зэрэг арилжааны 6 банкаар дамжуулан магадлан итгэмжлэгдсэн 72 их, дээд сургууль, коллежийн өдрийн ангийн бакалаврын оюутан бүрт нээлттэй олгож байна.

Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан боловсролын чанар, ирээдүйн орлогод суурилсан “Оюутны хөгжлийн зээл”-ийн журмын 2.2, 4.6, 4.6.2-т зааснаар тус зээл нь арилжааны банкаар олгогдох, эргэн төлөгдөх нөхцөлтэй бөгөөд арилжааны банкны журмын дагуу/тодорхой орлоготой иргэн батлан дааснаар/оюутнаас барьцаа хөрөнгө, орлого шаардахгүй байгаа гэдгийг таньд уламжлахад таатай байна.

“Оюутны хөгжлийн зээл”-ийг шаардлагатай оюутан бүрт хүртээмжтэй, чирэгдэл багатай олгох тал дээр тус яам идэвх санаачлагатай, шат дараатайгаар асуудлуудыг шийдвэрлэн ажиллаж байгаа бөгөөд Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд танилцуулахаар төлөвлөсөн байгааг уламжилъя.

Ж.БАТСУУРЬ